



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/009/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgongbayarts@audit.gov.mn
2026 он	Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ө.СУВДАА ТАНАА

2026.02.25 № ЦА-2026/009-НА-СТА-ТУЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн хөрөнгө оруулалтаар 150,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Ланд круйзер 76, ОБЕГ-аас 245,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Ниссан патрол LC300 маркийн автомашиныг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, аймгийн ИТХ-д 245,000.0 мянган төгрөгийн Ниссан патрол маркийн автомашиныг шилжүүлэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ нь 2021 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь тухайн цаг үеэс хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлтүүд мөрдөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 7 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 95.3 хувьтай дүгнүүлсэн байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		282,651,477.49	224,288,997.40
33	АВЛАГА	5	125,437,235.49	100,843,329.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		739,500.49	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		11,255,100.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага		113,442,635.00	100,843,329.80
35	БАРАА МАТЕРИАЛ		157,214,242.00	123,445,667.60
35100	Түүхий эд материал		2,725,000.00	125,000.00
35130	Эм боох материал		2,725,000.00	125,000.00
35400	Хангамжийн материал		154,489,242.00	123,320,667.60
35410	Бичиг хэргийн материал		14,950,454.00	3,225,699.60
35420	Аж ахуйн материал		76,428,388.00	60,530,968.00
35430	Сэлбэг хэрэгсэл		-	10,335,000.00
35440	Түлш, шатах тослох материал		10,523,000.00	7,730,000.00
35450	Барилгын засварын материал		776,000.00	688,000.00
35460	Хүнсний материал		57,400.00	-
35470	Бусад хангамжийн материал		51,754,000.00	40,811,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,592,951,170.66	4,593,481,922.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	4,592,951,170.66	4,593,481,922.47
39200	Биет хөрөнгө		1,767,085,170.66	1,798,343,922.47
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,405,998,671.00	1,557,078,275.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-673,218,567.76	-754,127,676.19
39203	Авто-тээврийн хэрэгсэл		880,221,650.00	847,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-386,394,178.30	-375,516,686.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		810,403,292.61	834,844,892.61
39206	Хуримтлагдсан элэгдэл		-507,913,200.90	-608,434,565.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		519,304,137.06	519,304,137.06
39208	Хуримтлагдсан элэгдэл		-294,711,193.99	-346,034,655.80
39214	Бусад үндсэн хөрөнгө		78,940,100.00	198,969,318.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-65,545,539.06	-74,939,116.65
39300	Биет бус хөрөнгө		2,825,866,000.00	2,795,138,000.00
39301	Программ хангамж		10,593,000.00	10,593,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-10,093,000.00	-10,593,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		2,825,366,000.00	2,795,138,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	8	4,875,602,648.15	4,817,770,919.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		123,017,015.85	152,500,822.94
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	123,017,015.85	152,500,822.94
41300	Өглөг		123,017,015.85	152,500,822.94
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		-	7,720,000.00
41360	Бусад өглөг		123,017,015.85	144,780,822.94
41361	Байгууллагад төлөх өглөг		123,017,015.85	139,883,078.94
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		-	4,897,744.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,752,585,632.30	4,665,270,096.93
51	Засгийн газрын хувь оролцоо		4,752,585,632.30	4,665,270,096.93
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,765,498,366.00	2,765,498,366.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		2,765,498,366.00	2,765,498,366.00
51200	Хуримтлагдсан үр дүн		920,491,438.36	833,175,902.99
51210	Өмнөх үеийн үр дүн		-1,674,193,638.66	920,491,438.36
51220	Тайлант үеийн үр дүн		2,594,685,077.02	-87,315,535.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,066,595,827.94	1,066,595,827.94

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,875,602,648.15	4,817,770,919.87
---	--	------------------	------------------



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

1324100015 /төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	11,131,861,488.16	9,501,044,659.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,817,227,870.00	9,501,044,659.40
120	Нийтлэг татварын бус орлого		2,817,227,870.00	1,023,873,036.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		55,275,220.00	54,231,254.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		55,275,220.00	54,231,254.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		2,761,655,650.00	675,817,822.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		297,000.00	293,823,960.00
122	Тусламжийн орлого		-	8,477,171,623.40
1221	Хандив тусламж /дотоод/		-	8,477,171,623.40
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	6,683,471,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	6,683,471,200.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	1,793,700,423.40
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		-	35,684,393.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		-	429,823,149.20
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		-	1,328,192,881.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		8,314,633,618.16	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,997,314,360.54	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		464,583,934.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,504,823,823.54	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		27,906,603.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		6,317,319,257.62	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		6,317,319,257.62	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	8,537,149,056.44	8,953,172,568.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,537,149,056.44	8,953,172,568.16
210	Бараа, ажил үйлчилгээний зардал		8,107,341,407.65	8,449,871,694.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,147,682,114.79	3,850,224,782.72
210101	Үндсэн цалин		1,650,280,123.56	1,673,084,181.62
210102	Нэмэгдэл		1,106,465,866.23	1,420,014,037.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт		184,670,000.00	510,454,758.85
210104	Урамшуулал		206,266,125.00	220,459,553.50
210105	Гэрээт ажлын хөлс		-	26,212,250.94

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	371,673,531.58	459,217,723.03
210201	Тэтгэврийн даатгалын зардал	255,185,823.33	314,906,370.03
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	29,852,202.88	37,076,369.71
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	16,503,353.31	18,316,645.57
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	13,324,631.06	17,480,043.47
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	56,807,521.00	71,438,294.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	595,363,516.26	634,565,160.10
210301	Гэрэл, цахилгаан	29,632,447.26	38,382,092.21
210302	Түлш, халаалт	472,747,189.00	508,025,137.89
210303	Цэвэр, бохир ус	39,204,800.00	34,378,850.00
210304	Байрны түрээс	53,779,080.00	53,779,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	296,632,998.50	226,740,011.40
210401	Бичиг хэрэг	54,040,172.00	35,417,074.40
210402	Тээвэр, шатахуун	120,274,600.00	92,458,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,678,563.90	26,064,379.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	2,250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,919,662.60	70,549,758.00
2105	Нормативт зардал	4,058,750.00	1,213,600.00
210502	Хоол, хүнс	1,705,100.00	1,213,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,353,650.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	297,809,239.20	54,193,825.00
210602	Тавилга	218,828,000.00	-
210604	Урсгал засвар	78,981,239.20	54,193,825.00
2107	Томилолт, зочны зардал	185,377,934.40	154,521,200.00
210702	Дотоод албан томилолт	180,518,800.00	148,422,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,859,134.40	6,098,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,127,965.50	59,510,781.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,641,458.50	55,560,405.00
210803	Даатгалын үйлчилгээ	857,935.00	526,230.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	682,292.00	984,146.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	198,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,338,580.00	2,242,000.00
210807	Газрын төлбөр	4,409,700.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,132,615,357.42	3,009,684,610.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,824,341,246.50	2,645,005,284.88
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,539,866.00	16,023,322.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	270,734,244.92	348,656,003.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	429,807,648.79	503,300,873.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	229,915,399.95
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	229,915,399.95
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	229,915,399.95
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	229,915,399.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	378,727,451.75	273,385,474.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,414,900.00	81,228,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	195,102,797.00	14,770,390.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	169,209,754.75	177,386,584.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	51,080,197.04	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	51,080,197.04	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,594,712,431.72	547,872,091.24
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	27,354.70	635,187,626.61
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	27,354.70	281,396,344.61
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	333,694,785.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	96,497.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	-	20,000,000.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-27,354.70	-635,187,626.61
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,594,685,077.02	-87,315,535.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,369,908,838.16	8,674,977,605.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,332,734.00	8,674,977,605.75
120	Нийтлэг татварын бус орлого	71,332,734.00	54,231,254.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	55,275,220.00	54,231,254.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,275,220.00	54,231,254.00
120009	Бусад орлого	16,057,514.00	-
122	Тусламжийн орлого	-	8,620,746,351.75
1221	Хандив тусламж /дотоод/	-	8,620,746,351.75
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,683,471,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,683,471,200.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,937,275,151.75
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	35,684,393.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	429,523,149.20
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,472,067,609.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,298,576,104.16	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,981,256,846.54	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	464,583,934.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,504,823,823.54	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,849,089.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	6,317,319,257.62	-

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	6,317,319,257.62	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,269,579,163.16	8,660,245,005.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,269,579,163.16	8,660,245,005.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,726,328,859.37	8,013,069,403.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,137,228,727.08	3,850,224,782.72
210101	Үндсэн цалин	1,668,487,154.01	1,673,084,181.62
210102	Нэмэгдэл	1,077,694,524.88	1,420,014,037.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	186,592,160.71	510,454,758.85
210104	Урамшуулал	204,454,887.48	220,459,553.50
210105	Гэрээт ажлын хөлс	-	26,212,250.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	382,306,038.13	459,217,723.03
210201	Тэтгэврийн даатгалын зардал	261,678,119.18	314,906,370.03
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	33,923,533.50	37,076,369.71
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	16,504,978.19	18,316,645.57
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	13,326,225.94	17,480,043.47
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	56,873,181.32	71,438,294.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	595,363,516.26	634,565,160.10
210301	Гэрэл, цахилгаан	29,632,447.26	38,382,092.21
210302	Түлш, халаалт	472,747,189.00	508,025,137.89
210303	Цэвэр, бохир ус	39,204,800.00	34,378,850.00
210304	Байрны түрээс	53,779,080.00	53,779,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	223,171,316.70	167,374,054.00
210401	Бичиг хэрэг	36,839,900.00	17,928,110.00
210402	Тээвэр, шатахуун	95,286,300.00	80,850,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,674,039.90	27,448,846.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	2,250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	56,651,076.80	38,896,298.00
2105	Нормативт зардал	7,458,750.00	1,213,600.00
210502	Хоол, хүнс	1,705,100.00	1,213,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,753,650.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	296,868,389.20	53,050,625.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	218,810,000.00	-
210604	Урсгал засвар	78,058,389.20	53,050,625.00
2107	Томилолт, зочны зардал	191,637,700.00	150,831,636.00
210702	Дотоод албан томилолт	180,518,800.00	142,892,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	11,118,900.00	7,939,136.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,116,965.50	59,510,781.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,630,458.50	55,560,405.00
210803	Даатгалын үйлчилгээ	857,935.00	526,230.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	682,292.00	984,146.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	198,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,338,580.00	2,242,000.00
210807	Газрын төлбөр	4,409,700.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,814,177,456.50	2,637,081,041.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,776,537,590.50	2,621,057,719.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,639,866.00	16,023,322.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	543,250,303.79	647,175,602.30
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	373,790,128.30
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	373,790,127.70
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	373,790,127.70

2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	229,915,399.95
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	43,031,398.55
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	100,843,329.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	378,727,451.75	273,385,474.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,414,900.00	81,228,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	195,102,797.00	14,770,390.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	169,209,754.75	177,386,584.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	164,522,852.04	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	164,522,852.04	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	100,329,675.00	14,732,600.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	100,329,675.00	14,732,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	100,329,675.00	14,732,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	100,329,675.00	14,732,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	100,329,675.00	14,732,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	- 100,329,675.00	- 14,732,600.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/


Код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	-1,674,193,638.66	2,157,900,555.28
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	-1,674,193,638.66	2,157,900,555.28
9	Тайлант үеийн үр дүн	-	-	2,594,685,077.02	2,594,685,077.02
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	920,491,438.36	4,752,585,632.30
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	920,491,438.36	4,752,585,632.30
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	920,491,438.36	4,752,585,632.30
19	Тайлант үеийн үр дүн	-	-	-87,315,535.37	-87,315,535.37
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	833,175,902.99	4,665,270,096.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,015,781,100.00	6,507,787,054.05	507,994,045.95	92.8
12	Татварын бус орлого	7,015,781,100.00	6,507,787,054.05	507,994,045.95	92.8
120	Нийтлэг татварын бус орлого	45,000,000.00	54,231,254.00	-9,231,254.00	120.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	45,000,000.00	54,231,254.00	-9,231,254.00	120.5
122	Тусламжийн орлого	6,970,781,100.00	6,453,555,800.05	517,225,301.95	92.6
122005	Төсвөөс санхүүжих	6,970,781,100.00	6,453,555,800.05	517,225,301.95	92.6
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,015,781,100.00	6,507,787,054.05	507,994,045.95	92.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,015,781,100.00	6,507,787,054.05	507,994,045.95	92.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,706,045,200.00	6,234,401,580.05	471,643,619.95	93.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,000,061,900.00	3,824,012,531.78	176,049,368.22	95.6
210101	Үндсэн цалин	1,686,751,200.00	1,673,084,181.62	13,667,118.38	99.2
210102	Нэмэгдэл	1,909,435,400.00	1,420,014,037.81	489,421,362.19	74.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	296,208,000.00	510,454,758.85	-214,246,758.85	172.3
210104	Урамшуулал	107,667,300.00	220,459,553.50	-112,792,353.50	204.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	490,973,400.00	455,941,191.67	35,032,208.33	92.9
210201	Тэтгэврийн даатгал	333,861,900.00	311,629,838.67	22,232,061.33	93.3
210202	Тэтгэмжийн даатгал	39,277,900.00	37,076,369.71	2,201,530.29	94.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,901,900.00	18,316,645.57	5,585,254.43	76.6
210204	Ажилгүйдлийн даатгал	15,375,900.00	17,480,043.47	-2,104,143.47	113.7
210205	Эрүүл мэндийн даатгал	78,555,800.00	71,438,294.25	7,117,505.75	90.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	644,421,500.00	634,565,160.10	9,856,339.90	98.5
210301	Гэрэл, цахилгаан	46,029,500.00	38,382,092.21	7,647,407.79	83.4
210302	Түлш, халаалт	504,392,100.00	508,025,137.89	-3,633,037.89	100.7
210303	Цэвэр, бохир ус	37,559,500.00	34,378,850.00	3,180,650.00	91.5
210304	Байрны түрээс	56,440,400.00	53,779,080.00	2,661,320.00	95.3
2104	Хангамж, бараа материалын зардал	185,069,700.00	164,960,754.00	20,108,946.00	89.1
210401	Бичиг хэрэг	25,590,600.00	17,928,110.00	7,662,490.00	70.1
210402	Тээвэр, шатахуун	84,068,400.00	80,850,800.00	3,217,600.00	96.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,492,200.00	27,213,846.00	4,278,354.00	86.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,310,000.00	2,250,000.00	60,000.00	97.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	41,608,500.00	36,717,998.00	4,890,502.00	88.2
2105	Нормативт зардал	3,290,000.00	-	3,290,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,290,000.00	-	3,290,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,834,600.00	66,963,525.00	19,871,075.00	77.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,199,200.00	13,912,900.00	16,286,300.00	46.1
210604	Урсгал засвар	56,635,400.00	53,050,625.00	3,584,775.00	93.7
2107	Томилот, зочны зардал	156,260,000.00	150,831,636.00	5,428,364.00	96.5

210702	Дотоод албан томилолт	144,260,000.00	142,892,500.00	1,367,500.00	99.1
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	12,000,000.00	7,939,136.00	4,060,864.00	66.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,884,100.00	39,195,021.00	36,689,079.00	51.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,277,600.00	35,244,645.00	24,032,955.00	59.5
210803	Даатгалын үйлчилгээ	1,245,600.00	526,230.00	719,370.00	42.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,745,000.00	984,146.00	1,760,854.00	35.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	354,600.00	198,000.00	156,600.00	55.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,361,300.00	2,242,000.00	5,119,300.00	30.5
210807	Газрын төлбөр	4,900,000.00	-	4,900,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,063,250,000.00	897,931,760.50	165,318,239.50	84.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,045,000,000.00	881,908,438.00	163,091,562.00	84.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,250,000.00	16,023,322.50	2,226,677.50	87.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	309,735,900.00	273,385,474.00	36,350,426.00	88.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	309,735,900.00	273,385,474.00	36,350,426.00	88.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	81,228,500.00	81,228,500.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,770,390.00	14,770,390.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213,737,010.00	177,386,584.00	36,350,426.00	83.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	102	95	7.00	93.1
620001	Удирдах ажилтан	10	10	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	47	40	7.00	85.1
620004	Гэрээт ажилтан	45	45	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	102	95	7.00	93.1
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	50	42	8.00	84.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4	-	100.0
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	7	7	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	0	1.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	38	40	-2.00	105.3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		1,793,400,423.40 <small>1324100018 8083458</small>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,793,400,423.40
122	Тусламжийн орлого		1,793,400,423.40
1221	Хандив тусламж /дотоод/		1,793,400,423.40
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,793,400,423.40
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		35,684,393.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		429,523,149.20
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,328,192,881.20
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,793,400,423.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,793,400,423.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,793,400,423.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		26,212,250.94
210105	Гэрээт ажлын хөлс		26,212,250.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,276,531.36
210201	Тэтгэврийн даатгал		3,276,531.36
2104	Хангамж, бараа материалын зардал		2,413,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		235,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,178,300.00
2105	Нормативт зардал		1,213,600.00
210502	Хоол, хүнс		1,213,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		20,315,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		20,315,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,739,968,981.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,739,968,981.10

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **39,009.7** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **3,064.5** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **31,814.8** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **4,130.4** мянган төгрөгийн 2

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **34,879.3** мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 28,572.4 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт:

5.1.1. Албан хаагчдын цалин хөлстэй холбоотой нийт **3,064.5** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн ажилтан Ц.Бүжинд хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмжтэй давхардуулан 1,045.3 мянган төгрөгийн цалин олгосон,
- Үйлчлэгч Х.Буянхишигт 630.0 мянган төгрөг, жижүүр Б.Бямбажаргалд 450.0 мянган төгрөг, мэргэжилтэн Б.Гантуулд 300.0 мянган төгрөг, архивч Ц.Нямлхагвад 270.0 мянган төгрөг зэрэг нийт 1,650.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг илүү тооцож, олгосон,
- Ажилчдын бусдад өгсөн хандивыг цалингаас нь урьдчилан шилжүүлж, суутгалыг дараа нь гүйцэтгэж байгаагаас шалтгаалан 368.8 мянган төгрөгийн авлагыг дутуу суутгасан.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлт, цалин болон дутуу суутгасан авлагыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс буюу төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас ХХОАТ-ын **30,914.8** мянган төгрөгийн авлага үүсгэсэн боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг

хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд авлагыг үнэн зөв тусгах, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Тухайн байгууллагад ажилладаггүй 4 иргэнд /Л.Довчинбазар, Г.Сэржмядаг, Б.Отгонбаасан, Д.Лувсандагва/ нэг удаагийн тэтгэмж, урамшууллын батлагдсан төсвөөс **900.0** мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3. Нягтлан бодогч Ц.Уранцэцэг нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй буюу төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйгээс авлага үүсгэсэн, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалин хөлсийг зөрүүтэй тооцож олгосон зэрэг албан ажилдаа хариуцлагагүй хандаж, ихээхэн хэмжээний зөрчил дутагдал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “... хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Ц.Уранцэцэгт сахилгын шийтгэл ногдуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 445 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох болон актлах саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ¹4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг

¹ ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

5.3.2. Цалин хөлстэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга асан Х.Мөнхжаргал болон жижүүр Б.Сэлэнгэмөрөн нарын **4,130.4** мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын тайланд тайлагнаагүй нь НДШ, ХХОАТ-ын өр төлбөр үүсгэх эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 17.1.1: хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх," Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь "Татвар ногдох орлогод дараах орлого хамаарна" 6.3.1 дэх "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид албан хаагчдын цалинг нийгмийн даатгал болон татварын тайланд бүрэн тайлагнаж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлсийг илүү тооцож олгосон.	1	3,064.5	1	3,064.5								
ХХОАТ-ын авлага үүсгэсэн боловч санхүүгийн тайланд тусгаагүй.	1	30,914.8			1	30,914.8						
Тухайн байгууллагад ажилладаггүй хүмүүст тэтгэмж өгсөн.	1	900.0			1	900.0						
Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан.	1								1	1		
Нийгмийн даатгал болон татварын тайланд цалин дутуу тайлагнасан.	1	4,130.4					1	4,130.4				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг шийдвэрлээгүй.	1						1					
Дүн	6	39,009.7	1	3,064.5	2	31,814.8	2	4,130.4	1	1		

